



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн 2023 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2024/106/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Архангай аймаг 2024 он	Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Ахлах аудитор Г.Цог-Эрдэнэ Утас: 7033-3019 Цахим хаяг: Tsogerdeneg@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АРХАНГАЙ АЙМАГ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,  
Утас/Факс: (976) 7033 3141,  
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2024.02.07 № 06  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

АЙМГИЙН НАСАН ТУРШИЙН  
СУРАЛЦАХУЙН ТӨВИЙН ЗАХИРАЛ  
Х.ОТГОНЦЭЦЭГ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Насан туршийн суралцахуйн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Аудитын гол асуудал

Тайлангийн жилд төсөв захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн хүрээнд 2 арга хэмжээг улсын төсвөөс 192,880.6 мянга, орон нутгийн төсвөөс 37,891.7 мянга нийт 230,772.3 мянган төгрөгийг зарцуулан хэрэгжүүлсэн байна.

### Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 үндсэн зорилтын хүрээнд 24 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг Боловсролын ерөнхий газраас 91.7 хувьтай үнэлсэн байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>15,680,180.17</u></b>	<b><u>25,831,401.88</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	7,502,010.17	23,132,425.88
<b>312</b>	<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	7,502,010.17	23,132,425.88
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	7,502,010.17	23,132,425.88
31211	Төрийн сангийн харилцах	7,502,010.17	23,132,425.88
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	8,178,170.00	2,698,976.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	8,178,170.00	2,698,976.00
35410	Бичиг хэргийн материал	4,714,920.00	1,372,980.00
35420	Аж ахуйн материал	3,463,250.00	1,325,996.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>25,348,616.87</u></b>	<b><u>2,071,872,729.29</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	25,348,616.87	2,071,872,729.29
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	25,275,283.72	2,071,872,729.29
39201	Барилга, байгууламж, орон сууц	00.00	1,977,990,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-16,483,250.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	20,392,670.00	117,894,370.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-3,404,391.94	-14,457,046.28
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,193,000.00	12,143,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-3,132,694.34	-5,441,044.43
39217	Ном	226,700.00	226,700.00
39301	Программ хангамж	880,000.00	880,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-806,666.85	-880,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>41,028,797.04</u></b>	<b><u>2,097,704,131.17</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>10,997,723.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	00.00	10,997,723.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	00.00	10,997,723.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	10,997,723.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>41,028,797.04</u></b>	<b><u>2,086,706,408.17</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	41,028,797.04	2,086,706,408.17
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	41,028,797.04	2,086,706,408.17
51210	Өмнөх үеийн үр дүн	41,028,797.04	41,028,797.04
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	2,045,677,611.13
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>41,028,797.04</u></b>	<b><u>2,097,704,131.17</u></b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b><u>216,650,800.95</u></b>	<b><u>2,331,437,000.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b><u>46,726,800.95</u></b>	<b><u>2,071,428,500.00</u></b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	46,726,800.95	2,071,428,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	32,065,370.95	2,071,428,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	32,065,370.95	2,071,428,500.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого БМ	14,661,430.00	00.00

**Архангай аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн 2023 оны жилийн төсвийн гүйцэтгэл,  
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>169,924,000.00</b>	<b>260,008,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	144,307,400.00	208,511,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	144,307,400.00	208,511,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	00.00	11,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	11,000,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	25,616,600.00	40,497,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	25,616,600.00	40,497,500.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>171,922,003.91</b>	<b>285,759,388.87</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>171,922,003.91</b>	<b>285,759,388.87</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	171,914,367.91	283,153,560.98
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	115,037,505.37	163,365,567.29
210101	Үндсэн цалин	89,906,074.40	92,823,642.19
210102	Нэмэгдэл	11,226,034.23	30,885,661.98
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	10,409,998.29
210104	Урамшуулал	13,905,396.74	19,007,296.96
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	10,238,967.87
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	14,147,884.46	19,792,017.00
210201	Тэтгэврийн даатгал	9,701,678.20	13,458,719.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,141,121.61	1,583,249.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	899,597.49	1,266,339.00
210204	Ажилгүйдлийн даатгал	218,498.91	316,809.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,186,988.25	3,166,901.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	22,644,864.00	40,889,395.11
210301	Гэрэл, цахилгаан	524,684.00	560,259.23
210302	Түлш, халаалт	21,789,696.00	39,100,926.88
210303	Цэвэр, бохир ус	330,484.00	1,228,209.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,200,000.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,200,000.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,964,100.00	8,000,000.00
210604	Урсгал засвар	2,964,100.00	8,000,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	15,920,014.08	51,106,581.58
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,000,000.00	5,402,260.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,903,260.00	9,799,934.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	3,016,754.08	35,904,387.58
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	7,636.00	2,605,827.89
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	7,636.00	2,605,827.89
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,636.00	2,605,827.89
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>44,728,797.04</b>	<b>2,045,677,611.13</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	3,700,000.00	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	3,700,000.00	00.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-3,700,000.00	00.00
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>41,028,797.04</b>	<b>2,045,677,611.13</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>169,924,000.00</u></b>	<b><u>260,008,500.00</u></b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>169,924,000.00</b>	<b>260,008,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	144,307,400.00	208,511,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	144,307,400.00	208,511,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	00.00	11,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	11,000,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	25,616,600.00	40,497,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	25,616,600.00	40,497,500.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>162,421,989.83</u></b>	<b><u>233,378,084.29</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>162,421,989.83</b>	<b>233,378,084.29</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>162,414,353.83</b>	<b>230,772,256.40</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	115,037,505.37	163,365,567.29
210101	Үндсэн цалин	89,906,074.40	92,823,642.19
210102	Нэмэгдэл	11,226,034.23	30,885,661.98
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	10,409,998.29
210104	Урамшуулал	13,905,396.74	19,007,296.96
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	10,238,967.87
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	14,147,884.46	19,792,017.00
210201	Тэтгэврийн даатгал	9,701,678.20	13,458,719.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,141,121.61	1,583,249.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	899,597.49	1,266,339.00
210204	Ажилгүйдлийн даатгал	218,498.91	316,809.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,186,988.25	3,166,901.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	22,644,864.00	29,891,672.11
210301	Гэрэл, цахилгаан	524,684.00	560,259.23
210302	Түлш, халаалт	21,789,696.00	28,103,203.88
210303	Цэвэр, бохир ус	330,484.00	1,228,209.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,200,000.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,200,000.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,964,100.00	8,000,000.00
210604	Урсгал засвар	2,964,100.00	8,000,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	6,420,000.00	9,723,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,000,000.00	6,223,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,420,000.00	3,500,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>7,636.00</b>	<b>2,605,827.89</b>
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	7,636.00	2,605,827.89
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,636.00	2,605,827.89
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>7,502,010.17</u></b>	<b><u>26,630,415.71</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>11,000,000.00</b>

**Архангай аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн 2023 оны жилийн төсвийн гүйцэтгэл,  
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>11,000,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	00.00	11,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	11,000,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>00.00</b>	<b>(11,000,000.00)</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	7,502,010.17	15,630,415.71
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	7,502,010.17
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	7,502,010.17	23,132,425.88

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	00.00	13,156,023.33	13,156,023.33
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>00.00</b>	<b>13,156,023.33</b>	13,156,023.33
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	-658,754.14	-658,754.14
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>00.00</b>	<b>41,028,797.04</b>	41,028,797.04
D01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	<b>00.00</b>	<b>41,028,797.04</b>	41,028,797.04
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>00.00</b>	<b>41,028,797.04</b>	41,028,797.04
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	2,045,677,611.13	2,045,677,611.13
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>00.00</b>	<b>2,086,706,408.17</b>	2,086,706,408.17

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	ТАЙЛАНТ ОНЫ		Зөрүү	Хувь
		БАТЛАГДСАН ТӨЛӨВЛӨГӨӨ	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	214,969,000.00	192,880,584.29	22,088,415.71	89.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	214,969,000.00	192,880,584.29	22,088,415.71	89.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	214,969,000.00	192,880,584.29	22,088,415.71	89.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл УРАМШИЛ	182,440,900.00	163,365,567.29	19,075,332.71	89.54
210101	Үндсэн цалин	126,195,000.00	92,823,642.19	33,371,357.81	73.56
210102	Нэмэгдэл	50,140,500.00	30,885,661.98	19,254,838.02	61.60
210103	УНАА ХООЛНЫ ХӨНГӨЛӨЛТ	00.00	10,409,998.29	-10,409,998.29	-

**Архангай аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн 2023 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

210104	УРАМШУУЛАЛ	6,105,400.00	19,007,296.96	-12,901,896.96	311.32
210105	ГЭРЭЭТ АЖЛЫН ХӨЛС	00.00	10,238,967.87	-10,238,967.87	-
2102	АЖИЛ ОЛГОГЧООС НИЙГМИЙН ДААТГАЛД ТӨЛӨХ ШИМТГЭЛ	22,805,100.00	19,792,017.00	3,013,083.00	86.79
210201	ТЭТГЭВРИЙН ДААТГАЛ	15,507,500.00	13,458,719.00	2,048,781.00	86.79
210202	ТЭТГЭМЖИЙН ДААТГАЛ	1,824,400.00	1,583,249.00	241,151.00	86.78
210203	ҮОМШӨ-НИЙ ДААТГАЛ	1,459,500.00	1,266,339.00	193,161.00	86.77
210204	АЖИЛГҮЙДЛИЙН ДААТГАЛ	364,900.00	316,809.00	48,091.00	86.82
210205	ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ	3,648,800.00	3,166,901.00	481,899.00	86.79
2109	БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БУСАД ЗАРДАЛ	9723000.00	9723000.00	0.00	100.00
210901	БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БУСАД ЗАРДАЛ	6,223,000.00	6,223,000.00	0.00	100.00
210902	ХИЧЭЭЛ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ДАДЛАГА ХИЙХ	3,500,000.00	3,500,000.00	0.00	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	208,511,000.00	208,511,000.00	0.00	100.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	208,511,000.00	208,511,000.00	0.00	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	208,511,000.00	208,511,000.00	0.00	100.00
4	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	00.00	7,502,010.17	-7,502,010.17	-
5	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	00.00	23,132,425.88	-23,132,425.88	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	08.50	08.50	0.00	100.00
620001	УДИРДАХ АЖИЛТАН	01.00	01.00	0.00	100.00
620002	ГҮЙЦЭТГЭХ АЖИЛТАН	07.50	07.50	0.00	100.00
620003	ҮЙЛЧЛЭХ АЖИЛТАН	01.00	01.00	0.00	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	08.50	08.50	0.00	100.00
650004	СӨБ БОЛОН БАГА, ДУНД БОЛОВСРОЛЫН АЛБАН ХААГЧ (ТҮБД)	07.50	07.50	0.00	100.00
650009	ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БУСАД АЛБАН ХААГЧ (ТҮ)	01.00	01.00	0.00	100.00

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>11,000,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>11,000,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	11,000,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	11,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,000,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	11000000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	11,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,000,000.00

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайлангийн аудитаар 12,035.8 мянган төгрөгийн алдаа илэрч санхүүгийн тайланд залруулга хийлээ.

Залруулсан алдаа:

- Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 2023 оны 6 сараас 12 сар дуустал хугацаагаар тооцоолж бодоогүй 12,035.8 мянган төгрөгийн зөрүү үүссэн алдааг аудитын явцад залруулав. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4, 13.1 дэх заалт, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар залруулаагүй 4,400.0 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрч 1 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлээ.

### 5.1 Албан шаардлага

Насан туршийн боловсролын төвийн захирлын 2023.11.15-ны өдрийн Б/25 дугаар тушаалын дагуу албан хаагчдад 4,400.0 мянган төгрөгийн түлшний хөнгөлөлтийг цалингийн сангаас олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн Сайдын 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-тай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

### 5.2 Зөвлөмж

Тус байгууллагын дотоод хяналтын нэгж нь 2023 оны байгууллагын үйл ажиллагаа болон санхүү, төсвийн гүйцэтгэлд дотоод хяналтыг хэрэгжүүлсэн хэдий ч үр нөлөөг тооцож ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-д “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 4.1 дэх заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тухайн жилийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, хяналт шалгалтаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг үнэлж, үр нөлөөг тооцож ажиллах зөвлөмжийг хүргүүлэв.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2024 оны 03 дугаарын 01-ны дотор ирүүлнэ үү.

Зөвлөмжийн биелэлтийг тооцож, нотлох баримтыг хангуулан 2024 оны 06 дугаар сарын 20-ны дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Элэгдлийн зардлыг дутуу тооцсон	1	12,035.8	1	12,035.8			1	12,035.8				
Дүн	1	12,035.8	1	12,035.8			1	12,035.8				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Түлшний хөнгөлөлтийг цалингийн сангаас олгосон	1	4,400.0			1	4,400.0						
Дотоод хяналтын үр нөлөөг тооцож ажиллаагүй.	1						1					
Дүн	2	4,400.0			1	4,400.0	1					

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
НТСТөв	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
НТСТөв	0	0	0	0	0	0	0	0

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.